


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлд:

“Ү1.2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай авто замын өнөөгийн нөхцөл байдал, нүүрс тээвэрлэлтэд учирч байгаа хүндрэл бэрхшээлийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай авто замыг хэсэгчлэн богино хугацаанд чанартай засварлах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбатад даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР